



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
04 дүгээр сарын 30-ны өдрийн R-2025-21 дүгээр тогтоолын Хавсралт 1



ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДҮРЭМ

Хувилбар
Баталсан огноо
Баталсан
Боловсруулсан
Холбогдох эрх зүйн баримт
бичгүүд

Дагаж мөрдөх
Нэмэлт, өөрчлөлт оруулах,
шинэчлэх, хүчингүй болгох

1.0

2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба

- Компанийн тухай хууль
- Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн засаглалын кодекс
- ХасБанкны засаглалын кодекс
- ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөл

АГУУЛГА

1. НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХОРООНЫ ЗОРИЛГО
2. ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ХОРООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮТЭЦ
3. ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ХОРООНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА
4. ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ХУРАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА
5. ТАВДУГААР ЗҮЙЛ. ТАЙЛАГНАЛ
6. ЗУРГАДУГААР ЗҮЙЛ. БУСАД

Нэгдүгээр зүйл. Хорооны зорилго

- 1.1. ХасБанк ХК (“Банк”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Нэр дэвшүүлэх хороо (“Хороо”)-г ТУЗ-өөс Банкны хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, салбарын зохицуулагч байгууллага болон Банкны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагын өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд дор дурдсан чиглэлээр дэмжлэг үзүүлэх зорилгоор үүсгэн байгуулна. Үүнд:
 - 1.1.1. ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирал (“ГЗ”)-ын албан тушаалд сонгогдон томилогдох мэргэжлийн өндөр ур чадвартай нэр дэвшигчийг тодорхойлох, үнэлэх, ТУЗ-д санал болгох;
 - 1.1.2. ТУЗ-ийн бүрэлдэхүүн, олон талт болон үр нөлөөтэй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих; мөн
 - 1.1.3. Байгууллагын урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах үүднээс ТУЗ болон ГЗ-ын залгамж халааг бэлдэхэд зөвлөж мэдээлэл өгөх.

Хоёрдугаар зүйл. Хорооны зохион байгуулалт, бүтэц

- 2.1. Хороо нь ТУЗ-ийн 6 (зургаа)-аас доошгүй гишүүдээс бүрдэх бөгөөд үүнээс гуравны хоёр нь ТУЗ-ийн хараат бус, гүйцэтгэх удирдлагын бус гишүүн байна.
- 2.2. Хорооны даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор Хорооны гишүүдийн саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын саналыг Хорооны гишүүд заавал дагаж мөрдөх үүрэггүй болно.
- 2.3. Хорооны дарга хуралд оролцохгүй тохиолдолд тухайн хурлыг даргалах этгээдийг нэр дэвшүүлнэ. Хорооны дарга хурлыг даргалах этгээдийг нэр дэвшүүлээгүй бол тухайн хуралд оролцож байгаа гишүүд дундаасаа нэг гишүүнийг сонгож хурлын туршид даргалах түр орлон гүйцэтгэгчийг сонгоно.
- 2.4. Хорооны гишүүд цогцоор компанийн засаглал, ур чадварын удирдлага болон байгууллагын хөгжил зэрэг Банкны зорилго, стратеги төлөвлөлтөд шаардлагатай олон талт мэдлэг, чадвар, дадалыг эзэмшсэн байна. Гишүүн бүр холбогдох хууль тогтоомж болон засаглалын чиг хандлагын талаарх мэдлэгээ шинэчилж байна.
- 2.5. ТУЗ өөрийн зохистой гэж үзсэн хугацаагаар Хорооны гишүүдийг томилох буюу улируулан томилж болно. ТУЗ нь аль ч үед тодорхой шалтгаантай эсэхээс үл хамаарч Хорооны гишүүн болон Хорооны даргыг чөлөөлөх, солих бүрэн эрхтэй.

Гуравдугаар зүйл. Хорооны үүрэг, хариуцлага

- 3.1. Хороо нь дараах болон бусад үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 3.1.1. чадвар, мэдлэг, боловсрол, мэргэжлийн дадал, болон олон талт байдал зэрэг ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, үнэлгээний шалгуурыг боловсруулж, тогтмол хянах;
 - 3.1.2. Банкны хэрэгцээ, мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн шаардлага болон засаглалын шилдэг туршлагыг харгалзан үзэж ТУЗ-д нэр дэвших боломжит этгээдүүдийг тодорхойлох, үнэлэх. Ингэхдээ Хороо нь нэр дэвших этгээд тус бүрийн шударга байдал, хараат бус байдал, үүсэж болох ашиг сонирхлын зөрчлийг үнэлж, ТУЗ-тэй зөвшилцөн Банкны ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх болон түүний залгамж халааг бэлдэх ерөнхий журамд заасны дагуу шаардлага

- хангасан нэр дэвшигчийг томилох зөвшөөрөл авахаар Монголбанк болон хувьцаа эзэмшигч нарт мэдүүлэх;
- 3.1.3. Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйл болон Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасныг чанд баримтлан хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн этгээдүүдийг бүртгэж, тухайн нэр дэвшигчдийг томилох зөвшөөрөл авахаар Монголбанкинд шууд хүргүүлэх, түүнчлэн Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.5 дахь хэсэгт чанд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар ТУЗ-д уламжлах;
- 3.1.4. Жил тутам хийх ТУЗ-ийн үнэлгээ болон гишүүдийн харилцан үнэлгээг хариуцах, ингэхдээ ТУЗ-ийн гишүүн бүрийн гүйцэтгэлийг үнэлж, үр дүнг ТУЗ-д тайлагнах, мөн үнэлгээний үр дүнд тулгуурлан ТУЗ-ийн үр нөлөөтэй байдлыг сайжруулахаар санал гаргах;
- 3.1.5. Байгууллагын стратеги зорилт, хууль тогтоомжийн шаардлагад ТУЗ-ийн бүрэлдэхүүн нийцэж байгаа эсэхийг тогтмол үнэлэх, ТУЗ-ийн цогц ур чадварын түвшнийг хянаж, сайжруулах шаардлагатай дутагдалтай талыг чиглүүлэн зөвлөх;
- 3.1.6. ТУЗ-ийн дарга, Хорооны дарга болон бусад ТУЗ-ийн гол удирдах албан тушаалын залгамж халааны төлөвлөгөөг хянах, санал болгох, мөн удирдлагын тасралтгүй байдлыг дэмжих үүднээс төлөвлөсөн болон гэнэтийн нөхцөл байдалд залгамж халааг үргэлжлүүлэх талаар чиглүүлэх;
- 3.1.7. Мэдээлэлтэй үндэслэл бүхий шийдвэр гаргах болон ТУЗ-ийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулахад нь дэмжлэг үзүүлж, ТУЗ-ийн гишүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх цогц сургалт, мэргэших хөтөлбөрийг удирдан зохион байгуулах, мэргэжлийн ур чадварын тасралтгүй хөгжлийг хангах;
- 3.1.8. ГЗ-ыг сонгох тодорхой шалгуурыг боловсруулах, тогтмол хянах, шинэчлэх. Шалгуурт манлайлах ур чадвар, банкны салбар дахь туршлага, удирдлагын түүхэн гүйцэтгэл, Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс хараат бус байдал, байгууллагын соёлтой нийцэх нийлэмж, стратеги сэтгэлгээний чадавх, ёс зүйн хэм хэмжээ зэрэг хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй;
- 3.1.9. ГЗ-ын албан тушаалд төлөвлөсөн болон гэнэтийн сул орон тоо үүссэн тохиолдолд ТУЗ-тэй харилцан зөвшилцөж, ГЗ-д нэр дэвших боломжит этгээдүүд (байгууллагын дотроос болон гаднаас)-ийг байгууллагын стратеги зорилтыг хэрэгжүүлэх болон эрсдэлийг үр дүнтэй удирдах чадварыг үнэлэх зэрэг тогтоосон шалгуурын дагуу хайх, сонгох, үнэлэх, мөн ГЗ-ын албан тушаалд тохиромжтой гэж үзсэн шаардлага хангасан нэр дэвшигчдийг ТУЗ-д санал болгох; мөн
- 3.1.10. ГЗ-тай байгуулах гэрээний төслийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, цалин урамшууллын хорооны бүрэн эрхэд хамаарах цалин урамшуулалтай холбоотой хэсгээс бусад нөхцөлийг боловсруулах.
- 3.2. Хороо нь өөрийн үүрэг, хариуцлагатай холбоотой тодорхой асуудлуудад зориулсан тухайлсан бодлого, журамтай байж болох бөгөөд тэдгээр нь ТУЗ-өөс баталсан, энэхүү Дүрэмтэй нийцсэн байна. Тухайн баримт бичгүүд нь энэ Дүрмийн салшгүй нэг хэсэг болох бөгөөд Хороо нь тэдгээрийг чанд дагаж мөрдөнө. Хороо энэ Дүрэм болон холбогдох баримт бичгүүдийг зөрчсөн тохиолдолд ТУЗ-ийн өмнө хариуцлага хүлээнэ.

Дөрөвдүгээр зүйл. Хурал, үйл ажиллагаа

- 4.1. Хорооны хурал болон үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар зохицуулна.
- 4.2. Хорооны зөвлөмж болон шийдвэрийг тухайн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонх (гуравны хоёр)-ын саналаар батална.

Тавдугаар зүйл. Тайлагнал

- 5.1. Хорооны дарга (эсхүл тохоон томилогдсон гишүүн) Хорооны үйл ажиллагаа, дүгнэлт, зөвлөмжийг ТУЗ-д тогтмол тайлагнана.

Зургадугаар зүйл. Бусад

- 6.1. Хороо нь ТУЗ эсхүл ГЗ-д нэр дэвшүүлэх этгээдийг тодорхойлоход шаардлагатай гэж үзвэл аливаа хөндлөнгийн зөвлөх, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, хүний нөөцийн нийлүүлэлт хариуцсан мэргэжлийн байгууллагыг хөлслөх, хяналт тавих, гэрээгээ дуусгавар болгох бүрэн эрхтэй.
- 6.2. Хороо нь энэхүү дүрмийг хоёр жил тутамд хянаж, хууль тогтоомжийн шаардлага, засаглалын шилдэг туршлага болон байгууллагын хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлнэ. Хороо аливаа өөрчлөлтийн саналыг ТУЗ-д танилцуулж, батлуулна.